

## ДААТГАЛЫН САЛБАРЫН 2011 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2011 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 149 даатгалын салбар, 1992 даатгалын төлөөлөгч, 9 даатгалын зуучлагч компани, 7 даатгалын хохирол үнэлэгч компани, 12 актуарч, нийт 2186 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

(Хүснэгт-1)

**Даатгалын зах зээл дээрх тусгай  
зөвшөөрөл эзэмшигчдийн тоо**

№	Он	2008-II	2009-II	2010-II	2011-II
1	Даатгагч	16	17	16	17
2	Даатгалын компанийн салбар	109	130	134	149
3	Даатгалын төлөөлөгч	816	1233	2006	1992
4	Даатгалын зуучлагч	4	4	8	9
5	Даатгалын хохирол үнэлэгч			6	7
6	Даатгалын актуарч			10	12
	<b>Бүгд</b>	<b>945</b>	<b>1384</b>	<b>2180</b>	<b>2186</b>

Энэ оны 2 дугаар улирлыг өмнөх 3 жилийн мөн үеийн үзүүлэлттэй харьцуулбал даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 2008 оноос хойш 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс даатгалын компанийн салбарын тоо нэмэгдсэн нь тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн тоог өсгөсөн байна. Мөн даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчид шинээр нэмэгдсэн байна.

(График-1)



Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

Тайлант улиралд “Гранд даатгал” ХХК нь “Ард даатгал” ХХК-тай нэгдэж үйл ажиллагаа явуулж эхэлсэн, мөн шинээр “Мандал женерал” ХХК нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан.


Дээрх графикаас харахад дотоодын даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2009 оны тайлант үед 1384 байсан бол 2010 онд 2180, 2011 онд 2186 болж байна.

## II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Энэ оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 72.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.9 тэрбум төгрөг буюу 1.6 дахин өссөн байна. Мөн 2008 оны мөн үетэй харьцуулахад 37.3 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өссөн байна.

(График-2)

Àààðààèýí èîîàíéóáúí íééò ò°ð°íàèèí ðýìæýý, òýðáòì ò°ãð°ã°ð



2010 оны 2 дугаар улиралд даатгалын системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 40.4 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 89.2 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.8 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 10.8 хувийг эзэлж байсан бол 2011 оны эхний хагас жилд эргэлтийн хөрөнгө 61.1 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 84.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 11.1 тэрбум буюу нийт хөрөнгийн 15.5 хувийг эзлэж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин өссөн байгаа нь дүрмийн сангийн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэнтэй холбоотой юм. Нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жингийн өөрчлөлт өмнөх оны мөн үеэс нэмэгдэх хандлагатай байна.

**Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө**

(сая төг)

Үзүүлэлтүүд	2010-II		2011-II		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө						
Эргэлтийн бус хөрөнгө	40 425.3	89.2	61 120.2	84.5	20 694.9	-4.7
	4 868.6	10.8	11 126.9	15.5	6 258.3	4.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45 293.9</b>	<b>100.0</b>	<b>72 247.1</b>	<b>100.0</b>	<b>7 268.2</b>	

2010 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 66.7 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 20.8 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 10.5 хувийг дансны авлага, үлдэх 2.0 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг энэ оны мөн үетэй харьцуулахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 1.3 пунктээр богино хугацаат хөрөнгө оруулалт 0.3 пунктээр тус тус өсч, дансны авлага 1.4 пунктээр бусад эргэлтийн хөрөнгө 0.7 пунктээр тус тус буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 14.6 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд энэ нь Хорооны 2009 оны 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдсон даатгалын компаниуд дүрмийн сангийн хөрөнгийг мөнгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

(Хүснэгт-3)

**Эргэлтийн хөрөнгө**

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2010-02 улирал		2011-02 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,985.50	66.75	41,603.70	68.07	14,618.20	1.31
Богино хугацаат хөрөнгө оруулалт	8,426.70	20.85	13,297.10	21.76	4,870.40	0.91
Дансны авлага	4,235.40	10.48	5,508.30	9.01	1,272.90	(1.46)
Бусад эргэлтийн хөрөнгө	777.70	1.92	711.10	1.16	(66.60)	(0.76)
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>40,425.30</b>	<b>100.00</b>	<b>61,120.20</b>	<b>100.00</b>	<b>20,694.90</b>	<b>(0.00)</b>

2011 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 18.0 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 24.9 хувийг эзэлж байгаа бол “Жонон даатгал” ХХК хамгийн бага буюу 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 2.0 хувийг эзэлж байна

(Хүснэгт-3).

Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 42.6 хувийг даатгалын компани (“Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК)-ийн хөрөнгө бүрдүүлж байна.


(Хүснэгт-4)

	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төг/	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	5,137.7	7.1
2	Бодь даатгал ХХК	6,407.8	8.9
3	Ган зам даатгал ХХК	1,639.9	2.3
4	Мандал генерал даатгал ХХК	6,392.5	8.8
5	Жонон даатгал ХХК	1,453.9	2.0
6	МИГ даатгал ХХК	5,315.1	7.4
7	Монгол даатгал ХХК	18,015.0	24.9
8	Монгол траст холдинг даатгал ХХК	1,722.6	2.4
9	Моннис даатгал ХХК	1,528.2	2.1
10	Мөнх даатгал ХХК	1,467.9	2.0
11	Номин даатгал ХХК	3,623.0	5.0
12	Нэйшнл лайф даатгал ХХК	2,090.4	2.9
13	Практикал даатгал ХХК	4,614.7	6.4
14	Тэнгэр даатгал ХХК	5,235.0	7.2
15	Соёмбо даатгал ХХК	3,834.3	5.3
16	УБ даатгал ХХК	1,854.4	2.6
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	1,914.8	2.7
	<b>ДҮН</b>	<b>72,247.2</b>	<b>100.0</b>

### III. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 2 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад 2009 оны 2 дугаар улиралд нөөц сан 51.2 хувийг эзэлж байсан бол 2010 оны 2 дугаар улиралд 59.6 хувь болон өсч, 2011 оны 2 дугаар улиралд 47.0 хувь болон буурсан дүнтэй гарсан байна. Ийнхүү эзэмшигчийн өмчийн дүн өсч, нөөц сангийн үлдэгдэл буурсан нь компаниуд дүрмийн сангаа нэмэгдүүлэх болсонтой холбоотой.

(График-3)



Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр дахь эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн мөн онд 16.3 хувь байсан бол тайлант онд 5.1 хувь болж буурсаар байна. (Хүснэгт-5)

### Эзэмшигчдийн өмч

Санхүүгийн үзүүлэлт	2009 - II		2010 - II		2011 - II	
	тоо (тэрбум төг)	эзлэх хувь	тоо (тэрбум төг)	эзлэх хувь	тоо (тэрбум төг)	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	11.30	91.6	12.2	80.3	28.8	83.5
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1.04	8.4	3.0	19.7	5.7	16.5
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>12.34</b>	<b>100.0</b>	<b>15.2</b>	<b>100.0</b>	<b>34.5</b>	<b>100.0</b>

Энэ оны эзэмшигчдийн өмчийн дүнг 2009 оны тайлант үеийнхтэй харьцуулахад 22.16 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хуримтлагдсан ашиг сүүлийн 2 жил тогтвортой нэмэгдэж ирсэн бөгөөд даатгалын компаниудын цэвэр ашиг өсч байгааг харуулж байна.

### IV. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

2011 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 24115.1 сая төгрөг, урт хугацааны даатгагч 142.4 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү даатгалын нийт хураамжийн орлого олсон даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 5.7 их наяд төгрөг болсон байна.

Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 5394.3 сая төгрөг буюу 22.3 хувийг давхар даатгалд, 68.1 сая төгрөг буюу 0.3 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 18652.7 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2011 оны 2 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 22.5 хувь буюу 5459.8 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 16.2 хувь буюу 3919.2 сая төгрөгийг, “Миг даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 13.4 хувь буюу 3258.2 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 52.1 хувийг эзэлсэн байна.

Даатгалын компанийн нийт хураамжийн орлогыг тайлант оны 2 дугаар улирлыг өмнөх оны мөн үеийнхтэй даатгалын хэлбэрээр харьцуулж харуулбал хөрөнгийн даатгал 2054.5 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 3075.8 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 1340.4 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1042.7 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний

Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

зардлын даатгал 651.9 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 371.8 сая төгрөгөөр, ачааны даатгал 159.6 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 35.5 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 38.7 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 6.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, санхүүгийн даатгал 147.1 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 800.8 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 8.3 сая төгрөгөөр, мал амьтадын даатгал 1.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна. (Хүснэгт-6)

Даатгалын хэлбэр	2010.06.30	2011.06.30	Өөрчлөлт +/-, /-/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.2. Хөрөнгийн даатгал	3 676.3	5730.8	2054.5
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	3 644.1	6719.9	3075.8
1.8. Агаарын хөлгийн даатгал	1 384.4	2724.8	1340.4
1.10. Хариуцлагын даатгал	2 455.4	3498.1	1042.7
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1 898.8	2550.7	651.9
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1 384.5	1756.3	371.8
1.11. Санхүүгийн даатгал	657.4	510.3	-147.1
1.5. Барилга угсралтын даатгал	948.4	147.6	-800.8
1.4. Ачааны даатгал	316.3	475.9	159.6
2.1. Хугацаат амьдралын даатгал	42.4	34.1	-8.3
2.5. Эрүүл мэндийн даатгал	27.4	62.9	35.5
1.7. Мал амьтдын даатгал	1.7	0.6	-1.1
1.6. Газар тариалангийн даатгал			0.0
2.3. Хуримтлалын даатгал	0.2	38.9	38.7
2.4 Тэтгэврийн даатгал		6.5	6.5
<b>ДҮН</b>	<b>16 437.3</b>	<b>24 257.4</b>	<b>7 820.1</b>


## V. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2011 оны 2 дугаар улиралд нийт 4307.4 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн даатгалын, 34.7 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 36.4 сая төгрөгөөр, мал амьтадын даатгал 3.8 сая төгрөгөөр тус тус буурч, авто тээврийн хэрэгслийн даатгал 549.7 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 3.7 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 82.2 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 231.5 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 71.0 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 146.2 сая төгрөгөөр, ачааны даатгал 45.0 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 2.2 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 25.7 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 6.4 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлтгүйгээр нөхөн төлбөрт олгогджээ.

Даатгалын хэлбэр	2010.06.30	2011.06.30	Өөрчлөлт
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	615.1	580.4	-34.70
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	1511.6	2 061.3	549.70
1.8. Агаарын хөлгийн даатгал	1.7	5.5	3.80
1.10. Хариуцлагын даатгал	103	185.2	82.20
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	329.1	560.6	231.50
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	378.7	449.7	71.00
1.11. Санхүүгийн даатгал	204.4	350.6	146.20
1.5. Барилга угсралтын даатгал	37.7	1.3	-36.40
1.4. Ачааны даатгал	13.7	58.7	45.00
2.1. Хугацаат амьдралын даатгал	9.7	11.9	2.20
2.5. Эрүүл мэндийн даатгал	4.3	30.0	25.70
1.7. Мал амьтдын даатгал	9.6	5.8	-3.80
1.6. Газар тариалангийн даатгал			0.00
2.3. Хуримтлалын даатгал		6.4	6.40
<b>ДҮН</b>	<b>3218.6</b>	<b>4 307.4</b>	<b>1 088.8</b>

## VI. ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2011 оны 2 дугаар улиралд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 29.1 хувь болж 2010 оны мөн үеийнхээс 7.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 32.1 хувьтай харагдаж байна. (График-4).



Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2011 оны 2 дугаар улирлын байдлаар нөхөн төлбөрийн үзүүлэлт өндөр байгаа нь “Мөнх даатгал” ХХК 48.3 хувь, “Соёмбо даатгал” ХХК 48.2 хувь, “Номин даатгал” ХХК 45.7 хувьтай байна (Хүснэгт-8).

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2010-02	2011-02	
1	Ард даатгал ХХК	41.6	39.8	-1.77
2	Бодь даатгал ХХК	27.5	23.7	-3.82
3	Ган зам даатгал ХХК	8.6	8.1	-0.45
4	Мандал женерал даатгал ХХК	0	0.0	0.00
5	Жонон даатгал ХХК	0	32.4	32.40
6	МИГ даатгал ХХК	20.8	12.6	-8.18
7	Монгол даатгал ХХК	55.6	38.8	-16.83
8	Монгол траст холдинг даатгал ХХК	1.6	36.7	35.14
9	Моннис даатгал ХХК	0	1.7	1.72
10	Мөнх даатгал ХХК	15.7	48.3	32.63
11	Номин даатгал ХХК	36.1	45.7	9.62
12	Нэйшнл лайф даатгал ХХК	46.9	14.9	-31.98
13	Практикал даатгал ХХК	15.3	18.2	2.93
14	Тэнгэр даатгал ХХК	51.3	27.6	-23.68
15	Соёмбо даатгал ХХК	18.9	48.2	29.34
16	УБ даатгал ХХК	16.6	24.6	7.98
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	34.5	22	-12.50
	ДҮН	36.6	29.1	-7.50

Даатгалын компаниудаас 2010 оны 2 дугаар улиралд даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Номин даатгал” ХХК 9.62 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 32.63 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК /Хуучин нэрээр Түшиг даатгал ХХК/, 29.34 пунктээр өсч, “УБ даатгал” ХХК 7.98 пунктээр, “Монгол траст холдинг даатгал” ХХК 35.14 пунктээр “Практикал даатгал” ХХК 2.9 пунктээр тус тус өссөн бол, “Ард даатгал” ХХК 1.7 пунктээр, “Бодь даатгал” ХХК 3.82 пунктээр, “Ган зам даатгал” ХХК 0.45 пунктээр, “Миг даатгал” ХХК 8.18 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 23.68 пунктээр, “Монгол даатгал” ХХК 16.83 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 31.98 пунктээр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 12.5 пунктээр тус тус буурсан байна.

## VII. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2011 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3928.9 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 1272.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж




Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

нийт зах зээлийн 32.4 хувийг эзэлж байгаа бөгөөд “Практикал даатгал” ХХК 551.2 сая төгрөг буюу 14.0 хувь, “Бодь даатгал” ХХК 572.4 сая төгрөг буюу 14.6 хувь, “Номин даатгал” ХХК

293.6 сая төгрөг буюу 7.5 хувь, Тэнгэр даатгал” ХХК 283.5 сая төгрөг буюу 7.2 хувь, “Ганзам даатгал” ХХК 213.5 сая төгрөг буюу 5.4 хувийг тус тус эзэлж, эдгээр компаниуд нийт зах зээлийн 81.1 хувийг эзэлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд ашигтай ажилласан байна. (Хүснэгт-9)

	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	150.9	3.8
2	Бодь даатгал ХХК	572.4	14.6
3	Ган зам даатгал ХХК	213.5	5.4
4	Мандал женерал даатгал ХХК	(69.3)	-1.8
5	Жонон даатгал ХХК	79.2	2.0
6	МИГ даатгал ХХК	383.0	9.7
7	Монгол даатгал ХХК	1,272.7	32.4
8	Монгол траст холдинг даатгал ХХК	40.4	1.0
9	Моннис даатгал ХХК	59.0	1.5
10	Мөнх даатгал ХХК	3.9	0.1
11	Номин даатгал ХХК	293.6	7.5
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(119.8)	-3.0
13	Практикал даатгал ХХК	551.2	14.0
14	Тэнгэр даатгал ХХК	283.5	7.2
15	Соёмбо даатгал ХХК	70.5	1.8
16	УБ даатгал ХХК	78.7	2.0
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	65.0	1.7
	<b>ДҮН</b>	<b>3,928.4</b>	<b>100.0</b>


2011 оны 2 дугаар улиралд “Нэйшнл лайф даатгал” ХХК 119.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна. (График-5).



### VIII. ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2009 оны эхний хагас жилд даатгалын нөөц 19.5 тэрбум байсан бол 2010 оны мөн үед 26.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 7.4 тэрбумаар нэмэгдсэн байна. 2011 оны эхний хагас жилд даатгалын нөөц сангийн үлдэгдэл 2010 оны мөн үеийнхээс 7.0 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийн .. хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, .. хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, .. хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, .. хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сан, .. хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна. (График-6)




### IX. ДАВХАР ДААТГАЛ

2011 оны 2 дугаар улиралд ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй компани гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж

Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

5394.3 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 673.6 сая төгрөгөөр буюу 1.1 дахин өссөн дүнтэй гарсан байна. (График-7).



(Хүснэгт-10)

**Давхар даатгалын хураамж**

(сая төг)

№	Компанийн нэр	2010-II		2011-II		Өөрчлөлт	
		Тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	233.2	4.9	208.8	3.84	-24.4	(1.06)
2	Бодь даатгал	2140.1	45	1989.5	36.61	-150.6	(8.39)
3	Тэнгэр даатгал	1102.7	23.2	259	4.77	-843.7	(18.43)
4	Практикал даатгал	20.8	0.4	28.3	0.52	7.5	0.12
5	Миг даатгал	378.7	8	919.2	16.91	540.5	8.91
6	Монгол даатгал	689.3	14.5	279.9	5.15	-409.4	(9.35)
7	Номин даатгал	83.4	1.8	11.4	0.21	-72	(1.59)
8	Нэйшнл лайф даатгал	26.1	0.6	40.6	0.75	14.5	0.15
9	Гранд даатгал	72.5	1.6	0	-	-72.5	(1.60)
10	УБ даатгал			7.7	0.14	7.7	0.14
11	Соёмбо даатгал			1056.5	19.44	1056.5	19.44
12	УБ хотын даатгал			27	0.50	27	0.50
13	Ган зам даатгал			69.6		69.6	

Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга

					1.28		1.28
14	Моннис даатгал			537.3	9.89	537.3	9.89
		<b>4746.8</b>	<b>100</b>	<b>5,434.80</b>	<b>100</b>	<b>688</b>	<b>0</b>

2011 оны эхний хагас жилд гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 24.4 сая төгрөг, “Бодь даатгал” ХХК 150.6 сая төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 843.7 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 409.4 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 72.0 сая төгрөгөөр тус тус бууруулсан нь гадаадын давхар даатгагчид даатгах эрсдэлээ багасгасантай холбоотой байна. Мөн тайлант үед “Нэйшнл лайф даатгал” ХХК 14.5 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 540.5 сая төгрөгөөр, “Практикал даатгал” ХХК 7.5 сая төгрөгөөр тус тус давхар даатгалын хураамжийн хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. 2011 онд шинээр “УБ даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК, “Ганзам даатгал” ХХК, “Моннис даатгал” ХХК-иуд өөрсдийн эрсдэлээ даатгуулахаар гадаадын давхар даатгагчид хураамжийг төвлөрүүлсэн нь 2011 оны давхар даатгалын хураамжийг 1.1 дахин өсгөхөд нөлөөлсөн байна.

#### Х. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 2 дугаар улиралд нийт 8 компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлангаа ирүүлээгүй “Скай-эрдэнэ” ХХК-ийн хувьд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 212 тоот тогтоолоор түдгэлзүүлсэн. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 139.8 сая төгрөг болсон байна.

(Хүснэгт-11)

№	Даатгалын зуучлагч компанийн нэр	Үндсэн үйл ажиллагааны орлого /сая төг/	Эзлэх хувь хэмжээ
1	“Асимон брокерс” ХХК	16.8	12
2	“АМЕ” ХХК	6.9	4.9
3	“Ачит ундарга” ХХК	27.2	19.4
4	“Лоялти солюшн” ХХК	24.7	17.7
5	“Эм Жи Ай Би” ХХК	7.6	5.4
6	“Скай-Эрдэнэ” ХХК	Түдгэлзүүлсэн	
7	“Ренессанс групп” ХХК	20.5	14.7
8	“Жомолхари” ХХК	0.7	0.5
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	35.4	25.4
	<b>Нийт дүн</b>	<b>139.8</b>	<b>100</b>

“Аме” ХХК нь 1 дүгээр улиралд 6.9 сая төгрөгийн орлоготой ажилласан ба 2 дугаар улиралд үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй болно. “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Ачит ундарга” ХХК, “Лоялти солюшн” ХХК-иуд нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 62.5 хувийг эзэлсэн байна.

## XI. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд нийт даатгалын хохирол үнэлэгч компаниуд үндсэн үйл ажиллагааны орлого 78.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

(Хүснэгт-12)

	Даатгалын хохирол үнэлэгч компанийн нэр	Үйл ажиллагааны орлого	Эзлэх хувь хэмжээ
1	“Бест эстимэйт” ХХК	3.1	4
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	12.6	16
3	“Файн эстимэйт” ХХК	0	0
4	“Итгэлт эстимэйт” ХХК	49.3	63
5	“Мега марз” ХХК	0	0
6	“Вендо” ХХК	2.2	2.9
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	11.1	14.1
	<b>Нийт дүн</b>	<b>78.3</b>	<b>100</b>

“Итгэлт эстимэйт” ХХК-ийн орлого нийт даатгалын хохирол үнэлэгч компаниудын орлогын 63 хувийг дангаараа эзэлж байна.

## XII. ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл

*Даатгалын салбарын 2011 оны II улирлын санхүү, даатгалын нэгдсэн танилцуулга*

Эзэмшигчдийн тоо сүүлийн хоёр жилд нэлээд нэмэгдэж, даатгалын мэргэжлийн оролцогчийн зах зээл дээр хохирол үнэлэгч, даатгалын зуучлагч компаниуд шинээр бий болон нэмэгдэж байгаа нь энэ зах зээлийн өсөлт хурдацтай явагдаж харуулж байна.

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад даруй 1.6 дахин өсч 72.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант үеийн цэвэр ашиг 3.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 дахин өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи нэмэгдэж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч байгааг илтгэн харуулж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 7.8 тэрбум төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн дүнтэй гарсан нь даатгалын зах зээл өсч, энэ салбар идэвхтэй хөгжиж байгаа дүр зураг харагдаж байна. Манай дотоодын даатгалын салбарын голлох үзүүлэлтүүд өсөлттэй сайн гарч байгаа нь Монгол Улсын санхүүгийн зах зээл өсөж байгаагаар тайлбарлаж болохоор байна.

Даатгалын зохицуулалтын бодлогыг тууштай хэрэгжүүлж байгаагийн үр дүнд даатгалын салбарын хөгжил эрчимтэй явагдаж байгааг нь жил бүрийн статистик тоон мэдээллийн дүн илтгэн харуулж байна.

## ДААТГАЛЫН ГАЗАР